



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/182

Хэрлэн сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2, Захиргааны Ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд Хэрлэн сумын иргэн Г.Энхбаяр нь аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 31-ний Б/17 дугаартай захирамжийг хууль зүйн үндэслэлгүй болохыг тогтоолгох талаар гомдол гаргасан тул аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанд тайлбар гаргах итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Бат-Октябрь, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ нарыг томилсугай.

2. Ирүүлсэн өргөдөлд хариу тайлбар гаргаж Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийг танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Бат-Октябрь, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА